



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/50

Булган сум

Цэвэр усны даралтат цамхаг шинээр  
барих ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтын 73 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01/90 дугаар тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ сумын 5-р багт байрлах цэвэр усны даралтат цамхаг шинээр барих ажилд 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналтыг тогтмол тавьж, хүлээн авахыг Сэлэнгэ сумын засаг дарга (Б.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг хууль, журам гэрээний дагуу байгаль хамгаалах сангийн байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ